

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чойдор	Дугаар	L228
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Дашинчилэн сум
Төрсөн газар	Дашинчилэн сум	Төрсөн он	1912
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Эрдэнэ хамбын хүрээ	Сүм хийдийн дугаар	БУХӨ 055
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат



Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Эрдэнэ хамбын хүрээ

Д.Мөнхбат: За тэгэхээр Чойдог гуай Та Эрдэнэ Хамбын хүрээнд хэдэн настайгаасаа эхэлж суусан, хэдий үед хүрээ хийд татан бүүгдахад хаагуур байв ,одоо яг нас сүүдэр хэд хүрч байна энэ тухайгаа ярихгүй юу?

Чойдог: Би одоо нас сүүдэр 94, 95 -тай хүн юмаа.5 настай шавилан суусан хүн юмаа 5 настай Эрдэнэ Хамбын хүрээнд.Эрдэнэ хамба бол Халх монголын долоон хутагтын нэг Тамгатай хутагт байсан юм.Тэгээд чинь 4 аймагтай, за байз Тойслон, Пунцаглин, Дэмчиглин , Гончиглин гэж 4 аймагтай хүрээ байсиймаа.Тэгээд дацангууд бол Жүдтэй. Цандитай. Дуйнхортой ийм хүрээ байсаан. Энд ерөөсөө тэгээд дом тавьсаан.Дом болвол тийм уншлага... нэрийг нь давхцуулаад энэ толгой муудаад..ямар ч домьг тэгж 3 цээжлүүлдэг ай-гаар төгссөн дом тавьлаа.үгүй тэгээд одоо энэ 22 /1932он бололтой/ онд чинь намын татвар гэдэг юм авдаг байгаа

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

юм , одоо төрөөс . Тэгэхээр одоо тэрнээс дайжиж байгаа юмуу ухаан нь цэргийн бүртгэл авч ардын хувьсгалд цэрэгт явлаа

Д.Мөнхбат: Тэгэхээр Эрдэнэ Хамбын хүрээ таны тэр үед хичнээн ламтай байсан юм, ямар ямар цам майдар эргэдэг байсан юм энэ талаар?

Чойдог: Урд нэг тийм зарцтай тийм бүрээ үлээх...Тэр чинь аймаг аймаг нь зарцтай ш дээ.Одоо энэ хамбых болвол Эрдэнэ хамбынх монгол орны хойд зүгийн хавтгайд хачин дэгтэй цамтай. Сая одоо 29-нд өнгөрлөө дөө. Энэ сар бүрийн 29-нд цам гардаг.зуны адаг сарын 29-нд

Д.Мөнхбат:Тэгэхээр Эрдэнэ Хамбын хүрээ мэдээж тэр үеийн хүрээнүүдийн нэгэн адил бас цагийн хурлуудтай байсан байхаа. Тэгэхээр энэ ямар ямар цагийн хурлууд хаана хаана байсан юм бол оо?

Чойдог. Цагийн хурал бол одоо юу юмаа.. Зун бол хайлангийн хурал гээд 50, 60 хүн хайлангийн тусгай тийм номын хувцастай хайлан хийдэг байсан. Одоо тэгээд зун цагаар юу л их хуралдана даа жүд цанид .Одоо жүд цанид, та нарт ярих юм бол улс төрийн энэ харилцаа... тийм энийг их харьцдаг байсан юм.

Д.Мөнхбат: Тэгэхээр одоогийн энэ Бүрэгхангай сүм ч гэдэг юмуу, Хишиг-Өндөр сүм ч гэдэг юмуу, Дашинчилэн сүм ч гэдэг юмуу цагийн хурал явуулдаг тийм дуган байж л дээ тиймээ. Тэгэхээр одоо Эрдэнэ Хамбын хүрээний харъяа байсан юм болов уу яасын юм бол?

Чойдог: Өө тэгэлгүй яахав Эрдэнэ хамба чинь Замбуу уул байгаа юм, Замбуу уул гэдэг чинь Төв аймгийн Заамар сумыг хэлж байгаа юм, начин уул гэдэг нь урд талын Гүнгэрваатыг хэлж байгаа юм,Дандарваат гэдэг нь одоо энэ Дашинчилэнгийн урд талыг хэлж байгаа юм. Эрдэнэ хамбын отог юм.Отог гэхээр энэ засаг захиргаа юмуу одоо тийм л утгатай

Д.Мөнхбат:Тэгэхээр энэ Эрдэнэ Хамбын хүрээ бол Түшээт хан аймгийн томоохон хийд байсны хувьд бол хойд талын Дайчин вангийн хүрээ ч гэдэг юмуу, зүүн талын Соо Гүний хүрээ ч гэдэг юмуу эд нартай ер нь хэр холбоотой ажиллаж байсан юм бол ?

Чойдог: Тэрийг нь чухам сайн мэдэхгүй юм. Аргагүй энэ Түдэв гүний билүү ...Хөгний арын хийдийг Эрдэнэ Хамбатай холбоотой л гэдэг юм даа.

Д.Мөнхбат: Тэгэхээр монголын хүрээ хийдүүдээс том бага гэлтгүй бурханы номонд мэргэшсэн эрдэмтэй мэргэн лам нар олноор төрөн гаржээ.

Эрдэнэ хамбын хүрээний ямар ямар чадалтай эрдэмтэй лам нар байв?

Чойдог:Халхын Эрдэнэ хамба гэдэг бол баруун талаас залагдсан хүн, Богдоос Эрдэнэ хамбыг залсан юм гэнэлээ, гарал үүсэл нь Завхан зүгийн лам хүн .Завхнаас залчихаад Эрдэнэ хамба чинь манай монголын 8-р богд таалал төгсөөд тэгээд Эрдэнэ хамбыг залсан юм. Тэгээд Эрдэнэ хамба чинь номын абшиг хүртээд ...ярихын биш мундаг чадалтай хүн

Д.Мөнхбат: За тэгээд танайд өөр эрдэм чадалтай ямар ямар лам нар байв?

Чойдог: Аа тэд нарыг нь цугыг нь барьж аваад засгаас ямар гүрний ямар даалгавраар гэнүү барьж аваачаад одоо яасан даа..Олон гавж явсан даа

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Тэгэхээр мэдээж Эрдэнэ хамбын хүрээ энэ том хүрээ тэр дэргэдээ ном хийдэг бурхантай байсан гэж түүхэнд тэмдэглэсэн байна лээ.. Ном хийдэг бурхан гэж..тэр судар номыг хэвлэдэг, За мөн одоо монголын хүрээ хийдийн түүхэнд маш ховор дэгтэй тийм цам гардаг гэж бичсэн байгаа юм, мөн хамбаасаа гадна ширээт лам гэж тийм хүн байсан гэж...Тэгэхээр энэ ямар хүмүүс байсан юм бэ?

Чойдог: За даа ширээт лам гэдэг бол одоо яахав дээ, юу юм байна даа Намхайжанцан гэдэг эцэгтэй Эринлхам гэж хүнээс гарсан.Манай энэ Дойлонтын хутагт байсан байгаа юм.Халзан ширээт лам...Тэгээд одоо яахав дээ нэг сайхан дүртэй цэмцгэр лам л байгаад байсан Намайг жоохон байхад хүрээн дээр ихэнхдээ сууж байдаг тийм л лам байсан юм Ширээт лам гэдэг нь хүрээ хамбатай зэрэг зиндаа ойролцоо байсан юмуу. Тэгээл сүүлдээ баригдаад лявсан шүү дээ.

Д.Мөнхбат: Эрдэнэ Хамбын хүрээний гол шүтээн сахиус нь ямар бурхан байсан гэнэ лээ?

Чойдог:Гол Гурван бурхан .. Одоо тэр номын санд бийГандангийн номын санд уу гэж тодруулбал/ тийм тэнд бий. За тэгээд жамсран голдуу тахидаг байсан байхаа.

Д.Мөнхбат:Мөн одоо Гавжийн энэ тэр дамжаа барьдаг биз?

Чойдог: Тийм дамжаа байсан.Ном үзэж байж орноо тийшээ бас шалгуулна

Д.Мөнхбат: Жас Сангийн хувьд одоо хэр баялаг зузаан жас сантай байсан бэ?

Чойдог: Хойд Урд сүндүй гэдэг том жас байсан юм.

Д.Мөнхбат: Малтай юу?

Чойдог: Аа малтай. Сангийн мал гээл малтай байсан юм

Д.Мөнхбат: 1937, 1938 оны тухайн үеийн төр засгийн лам нар сүм хийдийн талаар буруу бодлогын нөлөөгөөр монголын Буддын олон сайхан хүрээ хийд олон мэргэн эрдэмтэй хутагт хувилгаанууд байхгүй болжээ. Тэгэхээр энэ гашуун хувь заяа Эрдэнэ Вангийн хүрээг бол тойрч гараагүй дайраад өнгөрсөн нь лавтай. Тэгэхээр 1937, 1938 оны тэр хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд Эрдэнэ вангийн хүрээнээс хичнээн лам баригдаж явсан юм бол , хэд нь эргэж ирсэн юм бол , хэд нь эргэж ирээгүй юм бол энэ талаар таньд санагдаж байгаа зүйл байна уу?

Чойдог: За даа энэ одоо миний мэдэхээр лав даг 30-аад шахуу гавжийг л аваад явсан байх. Эргэж ирээгүй ээ.Ирсэн ганц нэг л хүн байсан . Одоо тэр Уул ноёныг чинь хар далайд л аваачаад яачихсан юм гэнэ лээ

Д.Мөнхбат: Эрдэнэ вангийн хүрээ мөхөж байхад сүүлчийн хамба ямар хүн байсан юм бол?

Чойдог:. Надинжид гэж хүн байсан...Гавж

Д.Мөнхбат: Тэгэхээр 1937, 1938 оны тэр хэлмэгдүүлэлтээр лам нарыг нь барьж явчихаар хүрээ хийд сүм дуган нь эзгүйрээд ном судрыг нь шатаагаад байсан түүх байдаг. Зарим газруудад. Бас лам нарыг нь барьж явчихаад тэр дор нь одоо маргааш нь ч юмуу хүрээ хийдийг нь шатаагаад устгачихдаг ийм түүх байдаг. Тэгэхээр Эрдэнэ вангийн хүрээний хувьд бол яасан юм бол оо тэр сүм хийд дуганыг нь?

Чойдог:Тавинбал гэдэг хүн намайг хүүхэд байхад сумын дарга байсан юм. Тэгээд тэр хүн тэр шүтээн юмнуудыг аваачиж шатаагаад .устгаж байсан . Би жоохон хүүхэд байж дээ

Д. Мөнхбат: Тэгээд тэр дуган сүм тэр дороо тэгээд устсан уу? 1940,1950-аад оны нүүрийг үзсэн үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чойдог: Тэгээд би чинь одоо цэрэгт явчихсан юм. Намайг ирэхэд л юу ч үлдээгүй байсан

Д.Мөнхбат: Таны цэргээс ирсэн тэр үе хэдэн он бэ?

Чойдог: 1940 он

Д.Мөнхбат: Тэгвэл удаагүй юмуу даа тиймээ?

Чойдог: Тиймээ удаагүй

Д.Мөнхбат: Тэгээд бид нар бас нэг ийм мэдээлэл авсан юмаа. Булган аймгийн Хишиг-Өндөр сумын хүн хэлж байсан юм. Нилээн сумын хариуцлагатай ажилтан сумын засаг даргын орлогч ярьж байсан юм. Энэ Эрдэнэ Вангийн хүрээн дээр шүтэгдэж байсан Улаан жамсран бурхан одоо яг тэр хэвээрээ яг тэр чигээрээ манай Хишиг-Өндөр сумын нэг айлд хадгалагдаж байдаг аа гэсэн, Энийг та ер нь дуулсан уу?

Чойдог: Үгүй ээ дуулаагүй. Эрдэнэ хамбын болвол чулуун сахиус одоо номын санд байгаа. Бүр тэр Хатанбаатар барьсан түүхтэй сахиус юм гэнэлээ. Өшөө чинь хажуугаас нь нэг хүн Эрдэнэтэд нэг сахиус байдаг гэж бас ярьдаг юм гэнэ лээ гэхэд/ үгүй одоо өөр ч мэдэхгүй юм дааМанай энд нэг томоохон сахиус байж байгаад алдсан л даа

Д.Мөнхбат: Тэгэхээр Чойдор гуай, энэ Түдэв гүний хүрээ хэдий үед байгуулагдаж байсан юм, хичнээн тооны ламтай, ямархуу хурал ном хурдаг, том жижгийн хувьд хэр хэмжээний хүрээ хийд байсан юм бол?

Чойдор: Түдэв гүнийх бол Эрдэнэ зууд жоохон хүүхэд мөргөж байхаар бараг шахам тийм жаахан хүрээ байсан юм. Эрдэнэ хамбын тасархай гэж ч ярьдаг байсан юм. Ер нь тэр цамын дэг харахад Эрдэнэ хамбаас сурсан болов уу гэмээр хүүхэд байсан юм. Эрдэнэ хамба чинь дандаа ийм Хөгний хийдэд морилж байсан лам гэж байгаа шүү дээ

Д.Мөнхбат: Тэгэхээр энэ Түдэв гүний хүрээнд хичнээн орчим лам нар байсан юм бол, бид нар сая суурин дээр нь очиход 10 гаруй дацангийн суурь мэдэгдэж байх юм?

Чойдор: Чухам би одоо хэдийг нь нарийн хэлж мэдэхгүй юмаа. нэг тийм хаанахын салбар байдгийм, тэднийх нарийхан тийм салбартай л гэж манай сайчуул ярьдаг байсан шүү дээ

Д.Мөнхбат: Тэгэхээр энэ Түдэв гүний хүрээ Эрдэнэ хамбын хүрээ хоёр хоорондоо 60-аад км л зайтай Тэгэхээр энэ хоёр бол хоорондоо харилцан холбоотой л байсан баймаар юм. Таны бодлоор бол тухайн үед ямар байсан юм бол, бие биенийгээ хэр мэддэг байсан бол?

Чойдор: Тэрийг би одоо чухам сайн мэдэхгүй юм. Их балчир бага байсан .аргагүй л сайчуул ярьж байхыг дуулахад л Түдэв гүн энэ Эрдэнэ хамба хоёр харилцаатай л улсууд байсан байх. Түдэвийн цам, Эрдэнэ хамбын цам хоёр нэг дэгтэй гэж ярьдаг байсан юм.

Д.Мөнхбат: Тэгэхээр Түдэв гүний хүрээний нэр, Түдэв гүн гэж нэрлэгдсэн нэр 20-р зууны монголын нэлээн алдартай хуурч Түдэв гуайтай нэлээн холбоотой юмаа даа тиймээ?

Чойдор: Тийм байх, Түдэв хуурч гэдэг чинь одоо мөн байлгүй дээ

Д.Мөнхбат: Танилцуулган дээр нь тэгж бичсэн байна лээ

Чойдор: Намайг жоохон хүүхэд байхад

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

”Үеийн лам нар уйлж байна.

Үйлтэй хуурч нь хуурдаж байна

Захын хамбаа дээдэлж яв

Зэгсэн хуурч нь хуурдаад” гэдэгсэн

Д.Мөнхбат: За ингээд танд баярлалаа. Таны ингэж өөрөө шавилан сууж байсан Эрдэнэ хамбын хийдийн тухай өгсөн мэдээлэл, Түдэв гүний тухай бас сонссон дуулсан мэдээлэл тань манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Та улам үрт удаан насалж үр ач нараа тойруулан сууж энэхүү үлгэр домог мэт яриагаа хуучилж , үрт насалж удаан жаргаарай.

Чойдор: За баярлалаа